НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 10 өдөр Дугаар 58 Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид 7 барилга байгууламж
бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар тус тус баригдаж ашиглалтад орсон нийт 10,187,225,150 /арван тэрбум нэг зуун наян долоон сая хоёр зуун хорин таван мянга нэг зуун тавь/ төгрөгийн өртөг бүхий 7 барилга байгууламжийг хавсралт ёсоор нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

ДАРГА Ж.БАТБАЯСГАЛАН

1110100180

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 05 дугаар сарын
10-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр
1.	48 дугаар сургуулийн спорт заалны барилга	Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо	2020	774,208,400	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2.	Нийслэлийн Шүд, эрүү нүүрний төвийн барилга байгууламж	Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо	2018	4,626,500,760	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт
3.	Хот тохижилтын газрын автомашины гаражийн барилга	Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо	2020	1,488,360,119	
4.	Түргэн тусламжийн төвийн барилга байгууламж	Чингэлтэй дүүрэг, 14 дүгээр хороо	2020	903,911,457	
5.	90 үхрийн зогсоол бүхий иж бүрэн цогцолбор фермерийн аж ахуйн барилга байгууламж	Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Нарийний хөндийн Шар хоолойн аманд	2019	1,023,269,694	
6.	67 дугаар сургуулийн спорт заалны хүзүүвчний барилга	Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо, Баянхошууны хуучин эцэс	2020	201,591,110	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
7.	273 дугаар цэцэрлэгийн барилга	Сонгинохайрхан дүүрэг, 35 дугаар хороо, Орбитын 46 дугаар гудамж	2020	1,169,383,610	
НИЙТ ДҮН				**10,187,225,150**	